

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД,  
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛЫН ТӨСӨЛ**

---

2026 оны ... сарын ... өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

**Жагсаалт, аргачлал батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл ахуйн тухайн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлын жагсаалтыг нэгдүгээр , Хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах буюу зориулалтын байгууламжид устгах аргачлалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
САЙД

БАЙГАЛЬ ОРЧИН,  
УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН  
САЙД

Э.БАТШУГАР

Ц.ИДЭРБАТ

Ц.САНДАГ-ОЧИР

Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны ... сарын...-ны өдрийн.....дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

### АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ЖАГСААЛТ

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягд-лын дэд бүлэг	Хог хаягд-лын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
16		16 11	Үхсэн малын сэг зэм	16 12 02*	Халдварт өвчин, хордлогын улмаас үхсэн болон зориудаар устгасан мал, амьтны хүүр, сэг зэм	А
18	Хүн, мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, оношлогоо, тусламж үйлчилгээний явцад үүсэх хаягдал	18 01	Хүний эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ, төрөлт болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	18 01 02*	Эмгэг хог хаягдал (хүний биеийн эд эрхтэн, хэсэг болон цус, цусан бүтээгдэхүүн, нөөцөлсөн цус (18 01 03-д зааснаас бусад))	А
				18 01 03*	Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал	А
				18 01 07*	Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал (Цитотоксик, цитостатик эм гэх мэт)	А
				18 01 09*	Шүдний эмнэлгийн амальгам хаягдал	А
				18 01 10*	Халдвартай шингэн хаягдлын анхан шатны цэвэрлэгээнээс үүсэх лаг	А

		18 02	Мал, амьтны эрүүл мэндийн оношлогоо, эмчилгээ, судалгаа болон урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанаас үүсэх хаягдал	18 02 02*	Цуглуулах, устгахад тусгай шаардлага тавигддаг халдвартай хаягдал	А
				18 02 06*	Эсэд хортой нөлөөтэй хог хаягдал (Цитотоксик, цитостатик эм гэх мэт)	А
19	Хог хаягдал устгах, боловсруулах байгууламж, хаягдал ус цэвэрлэх байгууламж, хүн амын хэрэглээний болон үйлдвэрлэлийн зориулалттай усыг урьдчилан боловсруулах байгууламжаас үүсэх хаягдал	19 01	Хог хаягдал шатаалт болон пиролизын боловсруулалтаас үүсэх хаягдал	19 01 02*	Хийн цэвэрлэгээнээс үүсэх фильтрийн тоос	А
				19 01 03*	Хийн цэвэрлэгээнээс үүсэх шингэн хаягдал болон бусад шингэн хаягдал	А
				19 01 04*	Хийн цэвэрлэгээнээс үүсэх хатуу хаягдал	А
				19 01 05*	Хийн цэвэрлэгээнд ашигласан идэвхжүүлсэн нүүрс	А
				19 01 06*	Хортой бодис агуулсан зуухны доод үнс ба шаар	А

Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны ... сарын...-ны өдрийн.....дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

Хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд аюултай хог хаягдлыг эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэх, тогтоосон тусгай цэгт булшлах буюу зориулалтын байгууламжид устгах аргачлал батлах тухай

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Зоонозын халдварын тандалт, оношилгоо, судалгаа, шинжилгээний үед үүссэн мал, амьтны сэг зэм зэрэг эмгэг хог хаягдлыг устгахад энэхүү тушаалыг мөрдөнө.

1.2. Эмгэг хог хаягдлыг шатаах, булшлах, тээвэрлэх, устгахад хэрэглэсэн эд зүйлс, хамгаалах хувцас хэрэглэл, лабораторийн оношилгоо, шинжилгээнд ашигласан материал, өсгөвөр, тэжээлт орчныг аюултай хог хаягдлын ангиллын дагуу ялган цуглуулж, нийтлэг зааврыг баримтална.

1.3. Зоонозын халдварын үед мал, амьтны сэг зэм зэрэг эмгэг хог хаягдлыг дараах аргуудаар устгана. Үүнд:

1.3.1. Аюултай хог хаягдал устгах төвлөрсөн байгууламжтай, агаарын шүүлтүүртэй, зориулалтын, өндөр хэмд шатаах зуухтай газарт мал амьтны сэг зэм зэрэг бүх эмгэг хог хаягдлыг өндөр хэмд шатааж устгана;

1.3.2. Аюултай хог хаягдал устгах төвлөрсөн байгууламжгүй, зориулалтын, өндөр хэмд шатаах зуухгүй газарт боом болон бусад үр үүсгэдэг нянгийн халдварын сэжигтэй эмгэг хог хаягдлыг энэхүү зааврын 2 дахь хэсэгт заасны дагуу шатааж устгана. Шаталтаас үлдсэн хог хаягдлыг хөрсөнд булна.

1.3.3. Зориулалтын, өндөр хэмд шатаах зуухгүй газарт үр үүсгэдэггүй, гадна орчинд тэсвэрлэх чанар багатай бичил биетнээр үүсгэгдсэн зоонозын халдварын үед эмгэг хог хаягдлыг энэхүү зааврын 3 дахь хэсэгт заасны дагуу булшлах аргаар устгана.

1.4. Мал, амьтны сэг зэм зэрэг эмгэг хог хаягдлыг устгахын өмнө халдваргүйжүүлэх бодис хийх шаардлагагүй.

1.5. Хог хаягдлыг булшлах ажилчид хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дагуу халдвараас сэргийлэх зааврыг мөрдөж, шаардлага хангасан хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөж, ажлын багаж хэрэгсэл (хүрз, жоотуу, лоом гэх мэт)-ээр бүрэн хангагдсан байна.

1.6. Хээрийн нөхцөлд булшлах газрыг усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсээс гадагш буюу усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд сонгоно.

1.7. Аймаг, орон нутгийн зоонозын евчин судлалын төвүүд нь зориулалтын шатаах зуухгүй бол байгаль орчны улсын байцаагчтай зөвшилцөн эмгэг хог хаягдлыг булшлах газрыг сонгоно. Тандалт, оношилгоо, судалгаа шинжилгээний явцад үүссэн эмгэг хог хаягдлыг булшлах нүхтэй байна. Булшлах нүх нь Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/173 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Эхэсийн нүхэнд тавигдах шаардлага” хангасан байна.

## Хоёр. Шатааж хөрсөнд булшлах арга

- 2.1. Шатааж хөрсөнд булшлах аргыг хэрэглэх үед мод, түлш, шатамхай бодис (бензин, дизелийн түлш, керосин) зэргийг шаардлагатай хэмжээгээр бэлтгэсэн байна.
- 2.2. Шатаах хог хаягдлын хэмжээнээс хамааран тэгш өнцөгт хэлбэрийн нүхийг 1,5-2 метрийн гүн ухаж бэлтгэнэ.
- 2.3. Ухсан нүхний ёроолд мод өрж тавиад шатаах хог хаягдлаа байрлуулна. Дахин мод өрж дээрээс нь тавиад шатамхай бодисоо хангалттай хэмжээгээр асгана.
- 2.4. Галтай бамбарыг салхитай талаас холоос шидэж гал өгнө.
- 2.5. Хог хаягдлыг шатаж дуустал хяналт тавих бөгөөд шатаж дууссаны дараа шороогоор булж дарна.

## Гурав. Булшлах арга

- 3.1. Булшлах газрыг устгах амьтны төрөл зүйл (тарвага 2,5-3 кг, бусад жижиг мэрэгч 0,4-0,5 кг) болон тоо, хэмжээнээс хамааран тэгш өнцөгт хэлбэрийн нүхийг 2,5-3 метрийн гүн ухаж бэлтгэнэ. Шаардлагатай бол дахин шинэ нүх ухаж хог хаягдлыг булшилна.
- 3.2. Хог хаягдал булшлах газарт үнэр тархах, мэрэгч, шавж нэвтрэхээс сэргийлж хог хаягдал хаях бүрт шороогоор хучна.

## Дөрөв. Булшилсан хог хаягдлын битүүмжлэл, хяналт

- 4.1. Булшлах нүх дүүрэх үед битүүмжилнэ. Битүүмжлэхдээ нүхийг 50 см-ээс доошгүй зузаан хөрсөөр дүүргэж сайтар чигжинэ. Нүхийг шороогоор дүүргэж чигжиж дараа нь газрын гадаргаас дээш 50 см өндөр шороо овоолно.
- 4.2. Булшилсан газар цагаан дэвсгэр дээр улаан өнгөөр бичсэн “АНХААР” гэсэн анхааруулга тэмдэг байрлуулна.
- 4.3. Хээрийн нөхцөлд булшилсан хог хаягдлын газрын нэр болон байршлыг газар зүйн байршил тогтоогч багажаар (GPS) тэмдэглэнэ.
- 4.4. Хог хаягдлыг булшлан устгасан тухай тэмдэглэл хөтөлж анхан шатны бүртгэл маягтад тэмдэглэн тайлагнаж баримтжуулна. Булшилсан газрын мэдээлэл, хог хаягдал устгасан тухай тэмдэглэлийг харьяа орон нутгийн Байгаль орчны газар болон Засаг даргын тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ.